



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2019 он 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар ХЭР  
1697

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Б.БАТТӨМӨР ТАНАА

Хуралдааны тэмдэглэл  
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төслийг  
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0006921

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд:

“ХI.ХЭЛЭЛЦСЭН нь:

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн санаачлан боловсруулсан Актив удирдлагын тухай хуулийн төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1. Хуулийн төслийн үзэл баримтлалын “Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага” хэсэгт “Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2 дугаар хавсралтын 4-т “арилжааны банкуудын оролцоотойгоор активын удирдлагын институци байгуулж, банкны системийн чанаргүй зээлийн хэмжээг бууруулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах...” гэж заасан байна.


Гэтэл банкуудад үүссэн чанаргүй зээлийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд шилжүүлэхээр зохицуулсан нь улсын төсөв, татвар төлөгчдийн хөрөнгөөр чанаргүй зээлийг хариуцах, банкууд чанаргүй зээлийн эрсдэлээ төрийн өмчийн оролцоотой институцид үүрүүлэх сонирхлыг бий болгох, банкуудын зээлийн үйл ажиллагааны зөрчил дутагдал цаашид хэвээр үргэлжлэх сөрөг үр дагавар дагуулж болзошгүй байна.

Иймд Засгийн газрын зээл, дамжуулсан зээл, санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн чанаргүй актив, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодын чанаргүй активыг зах зээлийн зарчмаар зохицуулах нь зүйтэй.

2. Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэгт чанаргүй активыг шилжүүлэн авах нөхцөл, шаардлагыг хэт өндөр тогтоосон нь цаашид банкууд зээлийн барьцаа хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур үнэлэх нөхцөлийг бүрдүүлж, зээлдэгч нарт дарамт учруулахаар байна.

Түүнчлэн хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг дан ганц банкны чанаргүй активыг шилжүүлэн авсан хүрээгээр хязгаарлан зохицуулсан, банк бус санхүүгийн байгууллага, зээлийн үйлчилгээ үзүүлдэг бусад хуулийн этгээдийн чанаргүй активыг хэрхэн зохицуулах талаар зохицуулалт байхгүй байна.

3. Хуулийн төсөл болон түүний үзэл баримтлалд банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгыг тодорхойлсон боловч зөвхөн нэг компанийн үйл ажиллагааг зохицуулсан, хуулийн төслийн зорилгод хамаарах асуудлыг бүрэн зохицуулаагүйгээс гадна хуулийн нэр болон үзэл баримтлалд нийцээгүй асуудлыг тусгасан байх тул хуулийн төслийг бүхэлд нь дахин нягтлах шаардлагатай байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

УХАД0064